

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 06 дугаар сарын 09

№07

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр ШУТИС-ийн эрдмийн зөвлөл 10:15 цагаас 91,3 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Аюурзана, Б.Оюунтунгалаг, Д.Биндиряа, Л.Амартүвшин, Б.Батдэмбэрэл, Б.Мөнхцэнгэл, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, М.Дэлгэрмаа, Р.Мядагмаа, Ц.Энхтуул, Г.Батцэцэг, Ч.Улам-Оргил, Д.Ариунболор, Г.Ариунтөгс нар оролцов.

Хэлэлцсэн асуудал:

1. Эрчим хүчний сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
- СЧА-ны дарга Ч.Улам-Оргил
2. Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
- СЧА-ны дарга П.Ууганбаяр
3. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн багийн ажлын үр дүн, дүгнэлт
- ХЕХ-ны гишүүн Ш.Цоож
4. Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц
- СЧА-ны дарга П.Булга
5. Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн хөтөлбөр боловсруулах үйл явц
- Захирал Б.Баяржавхлан
6. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн багийн ажлын үр дүн, дүгнэлт
- ХЕХ-ны гишүүн Ч.Улам-Оргил
7. Дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

№	Хэлэлцүүлсэн асуудал	Санал, зөвлөмж	ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:
1.	Эрчим хүчний сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын танилцуулга	<p>- Цөм хөтөлбөрийн шаардлагад тусгасан зарим хичээл хөтөлбөрт тусгаагүй байгааг дахин нягтлах;</p> <p>- Хөтөлбөрийн боловсролын зорилт, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хоорондын хамаарал гаргасан үзүүлэлтийг сайжруулах, оролцогч талуудын саналыг тусгах, ижил төстэй хөтөлбөртэй харьцуулалт хийх;</p> <p>- Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлах (хичээлийн кодлолтын зарчим баримтлах, багц цагийн задаргааг нягтлах, агуулгын давхардал үүсгэхгүй байхад анхаарах);</p> <p>- Хөтөлбөр хоорондын уялдааг хангах (хичээлийн улирлыг багшийн ачаалал, оюутны тоо, бусад бүрэлдэхүүн сургуулийн ижил төстэй хөтөлбөрийн агуулгатай нийцүүлэн төлөвлөх)</p> <p>- Хичээлээр олгох ур чадварууд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй хэрхэн яаж холбогдож байгааг зөв тодорхойлох;</p> <p>- Хичээлийн хөтөлбөрүүдийг ижил нэг загварт оруулах (ШУТИС-д мөрдөх жишиг загварын хүрээнд);</p> <p>- Техникийн болон механик алдаа нилээд байгааг засах (хичээл хоорондын уялдааг буруу төлөвлөсөн, үг үсгийн алдаа, санал болгох төлөвлөгөөнд сонгон кредит дутуу төлөвлөсөн, найруулгын алдаатай, сургалтын хөтөлбөр боловсруулах жишиг загварын бичиглэлийг шууд хуулсан байгааг анхаарах);</p> <p>- Хамтарсан хөтөлбөрийн боловсруулалт хангалтгүй байгаад анхаарч ажиллах, үндсэн хөтөлбөрт шилжин суралцагчид зөрүү гаргахгүйгээр боловсруулалт хийх, гадаад хэлний хичээлийг сургуулийн хэмжээнд нэгдсэн нэг зарчим баримтлах;</p> <p>- ХТКС хөтөлбөр нь БАС-ийн ХАСК сургалтын хөтөлбөртэй агуулгын давхардал үүсэх магадлал байгааг анхаарч 2 сургууль хамтран ажиллах;</p>	ЭХС-ийн бакалаврын 14 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (100%) дэмжлээ.
2.	Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн сургалтын хөтөлбөр	- Зарим хөтөлбөрийг цөм хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн дахин төлөвлөх (дадлагын хичээлийн кредитийг бага төлөвлөсөн, багц цагийн харьцааг хангах 30:30:40, хөтөлбөрийн ангилал зөв тодорхойлох);	

	<p>боловсруулах үйл явцын танилцуулга</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн боловсруулалт хангалтгүй байгаад анхаарч дахин ажиллах шаардлагатай (хөтөлбөрийн үзэл баримтлал хэсгийг боловсруулаагүй, зорилтуудын хоорондын хамаарлыг үгээр тодорхойлж бичих, сонгон судлах хичээл дутуу); - Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлах (сурах бичгийг шинэчлэх, агуулга шинэчлээгүй, хичээлийн кодлолын зарчим баримтлах, багц цагийн задаргааг нягтлах); - Хичээлийн хөтөлбөрүүдийг ижил нэг загварт оруулах (ШУТИС-д мөрдөх жишиг загварын хүрээнд); - Техникийн болон механик алдаа байгааг засах (найруулгын болон үг үсгийн алдаа, нийт кредитийн нийлбэр алдсан, сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлийн код бичигдээгүй, хуучин кодоор бичигдсэн, санал болгох төлөвлөгөөг дахин нягтлах, төгсөлтийн ажилтай хамт судлах хичээлийг зөв төлөвлөх); - STEEP, SWOT шинжилгээний үр дүнг дүгнэлт хэлбэрээр тайлбарлан бичиж оруулах; - Хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг дутуу гаргасан; - МХТС-ийн ХДХ-ны гишүүд хөтөлбөрийн боловсруулалтын явцад хяналт тавьж ажиллах; 	<p>МХТС-ийн бакалаврын 17 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүд, томилогдсон шинжээчийн саналыг тусган дахин сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (90%) дэмжлээ.</p>
<p>3.</p>	<p>Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын танилцуулга</p>	<ul style="list-style-type: none"> - Зарим хөтөлбөрт цөм хөтөлбөрийн шаардлага хангуулах; - Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг сайжруулах, нэгтгэх, оролцогч талуудын саналыг тусгах; - Хөтөлбөр боловсруулах загварын шаардлага хангаагүй байгааг жигдлэх; - Хөтөлбөрийн элсэлтийн бодлогыг төлөвлөлтийг сайжруулах; - Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин нягтлах (сурах бичгийг шинэчлэх, хичээлийн кодны зарчим баримтлах, багц цагийн задаргааг нягтлах); - STEEP, SWOT шинжилгээний үр дүнг дүгнэлт хэлбэрээр тайлбарлан бичиж оруулах; - Зарим хөтөлбөрт чанарын баталгаажуулалтын бүлгийг дэлгэрүүлж бичих (хүснэгт 8.12) 	<p>ҮТС-ийн бакалаврын 20 хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд эцэслэн хэлэлцүүлэхийг (100%) дэмжлээ.</p>

		<p>- Техникийн болон механик алдаа байгааг засах (найруулгын болон үг, үсгийн алдаа, санал болгох төлөвлөгөөг дахин нягтлах, өмнөх холбоо хичээлийг нэг улиралд төлөвлөсөн, хичээлийн код буруу бичсэн, судлах хичээл дутуу бичигдсэн);</p> <p>- Сургалтын хөтөлбөрийн нэршлийг олон улсын нэршил, хууль эрх зүйн баримт, салбар ямаас гаргасан дүрэм журамд нийцэх үндэслэлийг тодорхойлж, СБХА-д хүсэлт гаргах;</p>	
4.	<p>Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн хөтөлбөр боловсруулах үйл явц бусад бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөр дамжуулан хэрэгжүүлэлт, өөрийн сургуулийн сургалтын болон эрх зүйн орчны талаар танилцуулга</p>	<p>- Хөтөлбөр дамжуулан хэрэгжүүлж буй сургуулиудийн салбар, тэнхимтэй хамтын ажиллагаатай, санаачлагатай ажиллах (Орон нутгийн бүрэлдэхүүн, харьяа сургуулиудад бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааны удирдамж).</p> <p>- Цаашид дамжуулан хэрэгжүүлэх хөтөлбөрийн талаар бодлогын баримт боловсруулан зохицуулалт хийж ажиллах;</p> <p>- Хүний нөөцийн бодлогоо тодорхойлж, үндсэн багштай болох тал дээр ШУТИС-тай хамтран ажиллах;</p> <p>✓ Хөтөлбөрийн боловсруулалтад орон нутгийн сургууль идэвх санаачлагатай ажиллах, хамтын ажиллагааг сайжруулах</p> <p>✓ Хөтөлбөрийн үндсэн хариуцагч салбар дэмжиж ажиллах</p> <p>✓ Шаардлагатай тохиолдолд СБХА-аас зохион байгуулалт хийх</p>	<p>ӨмТДС-ийн бакалаврын 4 хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх хэлбэр гэдгээр, үндсэн хөтөлбөр хэрэгжүүлэгч салбар/ тэнхимтэй нягт хамтран ажиллах зөвлөмж өгөн, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд дамжуулан хэрэгжүүлэх хөтөлбөр хэлбэрээр танилцуулахыг дэмжлээ.</p>

Танилцсан:



Н.Эрдэнэхүү
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



М.Эрдэнэтуяа
/ХЕХ-ны нарийн бичгийн дарга/